



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 66 дугаар зүйлийн 3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 64 дүгээр тэмдэглэлийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн Гаалийн ерөнхий газар, түүний харьяа 10 гаалийн газарт төрийн өмчийн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд 2021 оны байдлаар хийсэн баримтын шалгалтаар нийт 113.7 (нэг зуун арван гурван сая долоон зуун мянга) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Шалгалтын тайланд дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дарга (Р.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

1.1.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 5.1.2 дахь заалтыг мөрдөж ажиллах;

1.2.Гаалийн байгууллагын системийн хэмжээнд бүртгэлгүй газрын мэдээллийг нарийвчлан гаргаж, газар эзэмших, ашиглах эрхийг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэлж санхүүгийн тайланд тусгаж, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах;

1.3.Улаанбаатар хотын Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянгол дүүргийн 1 дүгээр хороонд байршилтай, 653 м.кв талбай бүхий 21.1 (хорин нэгэн сая нэг зуун мянга) сая төгрөгийн балансын үнэтэй газрын эзэмших, ашиглах эрхийг Баянгол дүүргийн Татварын хэлтэст шилжүүлэх шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах;

1.4.Ховд аймгийн Булган дахь Гаалийн газрын барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй, одоо ашиглалтгүй байгаа хүнсний захын барилга, харуулын байрны газар эзэмшлийн асуудлыг шийдвэрлэх, хөрөнгийг худалдан борлуулах, өөр зориулалтаар ашиглах эсэх асуудлаар санал боловсруулан шийдвэрлүүлэх;

1.5.Гаалийн ерөнхий газар болон түүний харьяа газар, хороодын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, албаны зориулалттай орон сууцыг эзэмших, ашиглах журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж ажиллах;

1.6.Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй, төрийн эзэмшлийн газар дээр баригдсан хувийн орон сууцыг нүүлгэн шилжүүлж,

газрыг чөлөөлөх шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;

1.7.Гаалийн ерөнхий газар болон түүний харьяа газар хороод хооронд тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэх тохиолдолд зохих журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах;

1.8.Гаалийн бүс дэх төрийн байгууллагуудын ашиглаж байгаа төрийн өөрийн өмчийн байр талбайд хэмжилт баталгаажуулалтыг хийж хууль тогтоомж, журамд нийцүүлэн ашиглалтын гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авах;

2.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 26 дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газар, түүний харьяа 10 гаалийн газарт хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга		Мөнгөн дүн (сая төгрөг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Улаанбаатар хотын гааль	1.Нэмэлт төсвөөр ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө худалдан авсан. 2.Зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж үндсэн хөрөнгө бэлтгэсэн.	74.0	Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах, ТӨБЗГ-ын 271 дүгээр тогтоолын 2.4 дэх заалтыг мөрдөж ажиллах
2	Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар	Худалдан авах ажиллагааны журмыг зөрчсөн	39.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг болон Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах
Нийт дүн			113.7	(нэг зуун арван гурван сая долоон зуун мянга) сая